


БАТЛАВ:

МУИС-ийн оюутны хөгжил эрхэлсэн
захирал

Д-р Г.Галбаяр



“ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА”
СЭДЭВТ АНГЛИ ХЭЛЭЭР УРАН ИЛТГЭХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

2023.11.21

Улаанбаатар хот

Агуулга: МУИС-ийн Оюутны хөгжлийн бодлогын газраас “ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА” сэдвийн хүрээнд их сургуулийн оюутны хөгжлийн үйлчилгээг сайжруулах, гадаадын шилдэг их сургуулиудын туршлагаас суралцаж шинэлэг, үр дүнтэй санал санаачилгыг бодлого хөтөлбөртөө тусгах зорилгоор англи хэлээр уран илтгэх илтгэлийн тэмцээнийг зохион байгуулж байна. Оюутан залуус та бүхнийг англи хэлээр уран илтгэх чадвараа сорьж, оюутны хөгжлийн бодлого чиглэлийг сайжруулах тал дээр мэдлэг чадвараа хуваалцаж хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна. Төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургуулийн оюутан, залуус та бүхнийг идэвхтэй оролцохыг урьж байна.

Зорилго: Бакалаврын түвшний оюутнуудын англи хэлээр үзэл бодлоо цэгцтэй, ойлгомжтой, өөртөө итгэлтэй илэрхийлэх чадварыг дэмжих, тэдний оюутны хөгжлийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: Их, дээд сургуулийн бакалаврын түвшинд суралцаж буй суралцагч.

Сэдэв: “ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА” ерөнхий сэдэвтэй байна.

Илтгэл хүлээн авах хугацаа: Илтгэлийг 2023 оны 12-р сарын 05-ны 15:00 цагаас өмнө delger.s@num.edu.mn цахим хаягаар хүлээн авна.

Илтгэл шалгаруулах хугацаа: 2023 оны 12 сарын 07-нд өдрийн 15:00 цагаас шилдэг илтгэлүүдийг хэлэлцүүлнэ.

Хаана: МУИС-ийн Багш, оюутны хөгжлийн төвийн 502 тоот хурлын танхим

Холбоо барих утас: 77307730-1513, 89250099

Шагналын сан:

- Тэргүүн байр: Өргөмжлөл, мөнгөн шагнал 1.000.000 төгрөг
- 2-р байр: Өргөмжлөл, мөнгөн шагнал 500.000 төгрөг
- 3-р байр: Өргөмжлөл, мөнгөн шагнал 300.000 төгрөг
- Тусгай байр: Өргөмжлөл, мөнгөн шагнал 100.000 төгрөг

Илтгэлийн тэмцээнд оролцох, материал ирүүлэх зөвлөмж

Илтгэлийн нөхцөл ба шалгуур

- Илтгэлийн зохиомж, агуулга, ур чадвар, тайлбар, тухайн илтгэлийн чанарын шаардлага хангасан эсэхийг харгалзан шүүнэ.

Илтгэгч дараах зүйлийг анхаарна:

- Илтгэгч номоос эшлэл зүүлт авсан тохиолдолд түүнийгээ дурдах;
- Гадаад хэл дээрх илтгэлээс шууд хуулбарлахгүй байх;
- Бүтээлч, санаачилгатай хандах;
- Шагналт байранд шалгарсан, илтгэлүүдэд дурдсан шилдэг санааг цаашид оюутны хөгжлийн хөтөлбөрт авч ашиглах эрх нь МУИС-д үлдэхийг илтгэгч зөвшөөрөх;

Шүүгчдийн бүрэлдэхүүн: Зохион байгуулагч, дэмжигч байгууллага болон бусад их, дээд сургуулийн багш нарын төлөөлөл оролцсон нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.

Илтгэлийн шаардлага:

- Бичгийн стандартыг хангах;
- А4 цаасны хэмжээ дээр болон доороос 2см, зүүн талаас 3 см, баруун талаас 1.5 см;
- Arial 12 фонт үсгийн хэмжээтэй, сэдэв 14, илтгэгчийн нэр 12;
- Сэдвийн нэр;
- Сургуулийн нэр;
- Холбоо барих утасны дугаар;
- Цахим хаяаг;
- Мөр хоорондын зай 1.5см;
- Үгийн тоо 500-аас дээш байх;
- Илтгэлийн хугацаа 10-10 минут байх;

Тавигдах шаардлага:

- ❖ Уран илтгэх чадварыг эзэмшсэн байх
- ❖ Тодорхой нэг сэдэв, асуудлыг хөндсөн байх
- ❖ Санаагаа товч тодорхой илэрхийлсэн байх
- ❖ Оновчтой үг хэллэгийг хэрэглэх

МУИС-ийн ОЮУТНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ГАЗАР